

Living the Lotus

9
2021

VOL. 192

Buddhism in Everyday Life

Үүсгэн байгуулагчийн бодрол

Хүсэл шуналаас ангижруулах арга

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёкоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus
Vol. 192 (2021.09)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа
Эхийг хянасан: Монголын РКК,
Мөнхцэцэг
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон
улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-
international@kosei-kai.or.jp

Охиган (хавар, намрын өдөр шөнө тэнцэх өдөр) бол зовлон шаналал, төөрөгдөл тасралтгүй үргэлжлэх энэ ертөнцөөс бурханы ертөнцөд хүрэх зорилгоо эргэн санах өдөр юм.

Шагжамүни будда “Энэхүү судрыг сонсоод бурханы хутаг олохгүй хүн нэгээхэн ч үгүй” гэж баттай хэлсэн. Энэ судар гэдэг нь Цагаан лянхуа судрыг хэлж буй бөгөөд ямар ч хүнд будда болох хүслийг төрүүлж, бурханы ертөнц рүү хөтөлдөг.

Түүнчлэн Бурхан багш төөрөгдлийн ертөнцөд буй хүмүүс бидэнд хүсэл шуналаасаа ангижрахгүй бол аврагдахгүй гэж хүчээр тулгалгүй, өглөг буян үйлдэхийн сайхныг сургаж, аяндаа шуналын сэтгэлээс ангижрах замаар сургаалаа айлддаг. Мөн бусдад атаархаж, залхууралдаа хялбархан ялагддаг бидэнд хүний амьдралын жинхэнэ баяр баясал юу болохыг заан сургаж, бурханы сургаалыг хэрэгжүүлэхэд хялбар байдлаар удирдан чиглүүлдэг.

Буддын шашин бол үүнийг ч хийж болохгүй, түүнийг ч хийх ёсгүй зэргээр хориг тавьдаг номлол биш, харин сэтгэл өөдрөг бурханы түвшинд хүрэхэд тусалдаг сургаал юм.

«Үүсгэн байгуулагчийн үг» 10, X178-179

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



Ерөнхийлөгчийн айлдвар

Сайхан учралыг бий болгох нь

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо

Дээдийн учрал

Бид өдөр бүр янз бүрийн зүйлтэй учирдаг. Учралууд байгаа болохоор хүн амьд явдаг гэж ч хэлж болох биз ээ. Хүмүүс хоорондын учрал, элдэв үйл явдал, гэр бүлийнхэнтэйгээ өрнүүлэх ярианы нэгээхэн хэсэг ч тэр тухайн цаг мөчийн нөхцөл байдлаас бий болдог.

Бид тэдгээр учрал нэг бүрийг үргэлж сайн сайхан, баярлаж талархмаар зүйл байгаасай гэж хүсдэг боловч санаснаар болдоггүй нь хүний амьдралын жам. Ялангуяа хүмүүс хоорондын харилцаанд тааламжгүй, санааны зоргоор болохгүй зүйл тохиолдоход бид тэр учралыг сайнаар хүлээж авч чаддаггүй.

Шинто шашны Күрозүми урсгалыг үндэслэгч Күрозүми Мүнэтада (1780-1850) юу ч тохиолдсон “Сайн муу хосолдог нь хорвоогийн жам гэдгийг ухаарвал өчүүхэн ч зовлонгүй болно” гэж хэлдэг байсан гэдэг. Үүгээр дамжуулж “Сайн, муу ямар ч учралд талархаж амьдарвал танд тохиолдох учрал бүхэн талархмаар сайхан учрал байх болно” гэдгийг сургажээ.

Өөрөөр хэлбэл энэ ертөнцийн бүхий л үйл явдал жам ёсныхоо дагуу буюу орчлон ертөнцийн хуулийн дагуу явагддаг учраас эргэн тойрондоо болж буй учралуудыг сайн муу гэж ялгахгүй, аминч үзлээр хүлээж авахгүй байвал бүх зүйл шаардлагатай болоод л учирсан талархмаар учрал гэсэн үг.

Мөн олон янзын учрал, үйл явдлаар дамжуулж орчлон ертөнцийн хуулийг ухаарч, сурч мэдэж авч чадах юм бол тэр нь л чухамдаа өөрийгөө хөгжүүлэхэд шаардлагатай сайхан учрал болох юм. Буддын шашинтан хүний хувьд бурханы сургаалыг дамжуулах нь сайхан учралыг бий болгож буй явдал билээ. Тэгэхээр бурханы сургаалаар холбогдсон номын анд нөхөд бид дээдийн дээд сайхан учралаар дүүрэн жаргалтай хүмүүс юм.

Сэтгэлийн хандлага чухал

Ер нь бид яагаад сайхан учралыг хүсдэг юм бол?

“Тэр нь илүү сэтгэлд таатай шүү дээ” гэж өнгөцхөн бодох хүн олон байж магадгүй. Гэхдээ буддын сургаалаар бол хүн төрөлхийн бурханлаг мөн чанартай учраас үргэлж сайхан харилцааг бий болгохыг хүсдэг ажээ. Хүний сэтгэл зүрх ямагт бүх зүйлс эв найртай, амгалан тайван байгаасай гэж хүсдэг.

Бид нэгэнт ийм сайхан мөн чанартай учраас үе үе цухалзах хувиа хичээсэн зандаа ялагдалгүй, хэн нэгэнтэй учрах учрал, нөхцөл байдлыг зөв сайхан учрал болгохын тулд энэ учрал надад юу зааж сургаж байгаа юм бол гэсэн “учралаас суралцах хандлагатай байх”, олж анзаарсан зүйлээ “эргэцүүлэн боддог байх” чухал. Бурхан янз бүрийн хэлбэрээр сургаалаа айлдан орчлон ертөнцийн хуулийг сургадаг. Тиймээс хэн нэгэнтэй учрах учрал, аливаа үйл явдлаар дамжуулж Бурхан юу сургаж буйг олж харж чадах юм бол бүх учрал хэрэгтэй учрал болох юм.

Мөн Цагаан лянхуа судрын Гайхамшигт Чимэглэлт хааны урьд явдлыг үгүүлэх 27-р бүлэгт хүүхдүүд нь эцэг эхээ бурханы сургаалд хөтлөн оруулж буй тухай өгүүлдэг. Эцэг Гайхамшигт Чимэглэлт хаан нийгмийн байр суурь, нэр төрөө алдахаас айлгүй хүүхдүүдийнхээ зөвөлгөөг уян хатнаар сонсож, төлөв даруу сэтгэлээр бурханы сургаалд шамдаж буй тухай дүрсэлсэн байдаг.

Үүсгэн байгуулагч сайхан учралыг бий болгохын тулд “эхлээд бусдыг хүндлэх”, мөн “өөрийгөө мундаг харагдуулах гэсэн өчүүхэн аминч үзлээ хаях” чухал хэмээн айлджээ. Гайхамшигт Чимэглэлт хааны түүх шиг хандлага ямар байхаас шалтгаалаад үр хүүхэд нь эцэг эхийнхээ амьдралын сайн багш болж ч болно. Хүүхдийнхээ үгийг уян хатнаар хүлээж авч чаддаггүй “зөрүүд аав”-ын хувьд ингэж хэлэхээр байж боломгүй санагдаж магадгүй. Гэр бүл гэдэг дураараа загнах дуртай газар тул сайхан учралыг бий болгоё гэсэн хандлага бүр л чухал хэмээн би өөртөө анхааруулдаг.

Энэ сарын 10-ны өдөр бол Мёокоо багштаны “Ач буяныг хариулах өдөр” билээ. Тэрээр “Хүний сэтгэлийг сайтар ойлгож харилцвал ямар ч хүнтэй эвтэй байж чадна” гэж сурган, үргэлж бусдыг бодох энэрэнгүй сэтгэлийг тэргүүнд тавьдаг байсан. Мөн “Хүнийг аврахад хамгийн чухал нь чин сэтгэл” гэж хэлсэн ба үнэхээр ч бүхий л амьдралынхаа турш энэрэн нигүүлсэх сэтгэлийг мартаж байгаагүй. Тэрээр өвчин зовлон, ядуу тарчиг амьдралын шаналал гэсэн өөрийн амьдралын туршлагаар дамжуулж “Сайхан учралыг чин сэтгэл бий болгодог” гэсэн үнэнийг ухаарсан болов уу.

Тэгвэл бид эргэн тойрондоо байгаа зовж шаналж буй хүмүүсийн хүсэл найдварт хэрхэн хариулбал зохилтой вэ? Тэр чухал учралуудыг анзаарахгүй өнгөрч байгаа юм биш биз?

«Косей» 2021 оны 9-р сарын дугаар

Рисшо Косей Кай Нийгэмлэг

(Зурагт ном)

Үүсгэн байгуулагчийн намтар ба Рисшо Косей Кай нийгэмлэгийн түүх

Аавын сургаал



Үүсгэн байгуулагчийн аав Жүүкичи дуу цөөтэй, үнэнч шударга зантай хүн байсан ба тутаргын талбайд хичээнгүйлэн ажилладаг байжээ. Түүнчлэн яг л өвөө шиг нь өвдсөн хүнийг асарч сувиалан бэрхшээлтэй тулгарсан хүнийг зүгээр хараад суудаггүй байв.

Үүсгэн байгуулагчийг Токио руу ажиллахаар явах үед аав нь ийнхүү захисан гэдэг:

“Цалин багатай, ажлын цаг урт, хэцүү ажил сонгож хийгээрэй.”

Аавынх нь энэ үг хожим амьдралынх нь гол зарчим болсон хэмээн Үүсгэн байгуулагч дурссан байдаг.



Бяцхан мэдлэг

Аав Жүүкичи нь ч гэсэн 23 насандаа ажил хийхээр Токио явж байсан ба тэр үед орон нутгаас ирсэн олон залуус зугаа цэнгэл хөөн амьдралаа алдаж буйг харжээ. Тиймээс Үүсгэн байгуулагчид залхуу хойрго амьдарч болохгүйг анхааруулан ийн захисан ажээ.

Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.

Эхийн сургаал



Үүсгэн байгуулагчийн ээж Мий нь хэзээ унтдаг юм бол гэмээр унтах нойроо хугаслан хичээнгүйлан ажилладаг хөдөлмөрч хүн байв.

Тутаргын талбайд ажиллах, хоол унд хийж цэвэрлэгээ, угаалга хийх, юм нэхэх, кимоно оёх, хүр хорхой тэжээх гээд амрах завгүй ажиллана. Тэгсэн хэдий ч үргэлж инээмсэглэн хүүхдүүдтэйгээ эелдэг зөөлөн харилцдаг байв.


Үүсгэн байгуулагч ээжийнхээ энэ дүр төрхийг намтар номондоо “Үнэн сэтгэл, мөнх алдрын Дарь эх бурхан” хэмээн дурссан байдаг.



Бяцхан мэдлэг

Үүсгэн байгуулагч Сүганүма руу буцаа зуур ээж нь 43-хан насандаа өөд болжээ. Үүсгэн байгуулагч номондоо “Насан туршдаа ажлаас өөр зүйл мэдэлгүй, жаргал гэхээр жаргал амталж чадалгүй бурхан болсон эхийгээ бодохоор одоо ч нулимс тогтдоггүй юм” хэмээн дурссан байдаг.





Олон улсын хэлтсийн даргын булан

Аз жаргалын зурвасыг хайх

Бид энэ насандаа хүний төрлийг олоод зогсохгүй Үүсгэн байгуулагч, ерөнхийлөгчөөр дамжуулж учрахад бэрх Цагаан лянхуа судартай учирсан азтай хүмүүс билээ.

Энэ сард Нивано ерөнхийлөгч “Сайхан учралыг бий болгох нь” гэсэн сургаал айлдсан. Энэхүү учрахад бэрх номыг амьралдаа бүрэн дүүрэн ашиглаж, аз жаргалтай болоосой гэсэн Үүсгэн байгуулагчийн хүсэл зорилго шингэсэн айлдвар байсан.

Хүмүүс бидний мөн чанар бол бурханлаг чанар учраас үргэлж сайхан учралыг бий болгох юмсан, алив бүхэн бие биесээ дэмжиж, эв эетэй байгаасай гэж хүсдэг. Нөгөөтэйгүүр өөрт тохиолдох учралын утга учрыг бүрэн ойлгож, үнэ цэнийг нь гаргаж чадаж байгаа эсэхдээ итгэлгүй байх үе ч байдаг.


Нивано ерөнхийлөгч сайн сайхан учралыг бий болгох түлхүүр бол “хүн хоорондын харилцаа, аливаа үйл явдлаар дамжуулж Бурханы зурвасыг олж харах” хэмээн сургажээ. Түүнчлэн Үүсгэн байгуулагчийн айлдсан “эхлээд бусдыг хүндэтгэх”, “өөрийгөө мундаг харагдуулах гэсэн аминч үзлээ хаях” гэсэн сургаал сайхан учралыг бий болгоход ямар чухал болохыг сануулжээ.

Есдүгээр сар бол нигүүлсэхүйн бодисадва Мёокоо багштаны амин өдөр тохиох сар. Түүний амьдралаас суралцаж, хором мөч бүр тохиох учралд орших Бурханы чухал зурвасыг олж харж өдөр бүрийг өнгүүлцгээе.

Акагава Кэйичи



Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
 TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
 Email: sangha@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1809 Nani Street, Wailuku, HI 96793, USA
 TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
 TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
 TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
 Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

(Address) 1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
 (Mail) POBox 778, Pacifica, CA 94044, USA
 TEL: 1-650-359-6951 Email: info@rksf.org

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
 TEL: 1-212-867-5677 Email: rkny39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
 TEL: 1-773-842-5654
 Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

(Address) 2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
 (Mail) POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
 TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
 Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809, Denver, CO 80204, USA
 TEL: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
 URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
 TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-269-4567
 Email: info@rkina.org
 URL: <https://www.buddhistcenter-rkina.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
 (Mail) POBox 692148, San Antonio, TX 78249, USA
 TEL: 1-210-558-4430 FAX: 1-210-696-7745
 Email: dharmasanantonio@gmail.com
 URL: <http://rksabuddhistcenter.org>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
 TEL: 1-253-945-0024 Email: rkseattlewashington@gmail.com
 URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
 TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
 Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

在家佛教韓國立正佼成會 Korean Rissho Kosei-kai
〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

在家佛教韓國立正佼成會釜山支部

Korean Rissho Kosei-kai of Busan
〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人 在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Taipei
台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Tainan
台灣台南市東區崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: koseikaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai Society of Kolkata

89 Srirampur Road (VIP), Garia, Kolkata 700084, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001,
Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Please contact Rissho Kosei-kai Society of Kolkata

Rissho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,
Phnom Penh, Cambodia

RKISA Rissho Kosei-kai International of South Asia

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Bangkok

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dharma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Please contact Rissho Kosei Dharma Foundation

Rissho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL: 880-2-41360470

Rissho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka North

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Please contact Rissho Kosei-kai Bangladesh

Rissho Kosei-kai Patiya

Rissho Kosei-kai Ramu

Rissho Kosei-kai Aburkhill

Buddiyskiy khram "Lotos"

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Please contact Rissho Kosei-kai di Rome

Rissho Kosei-kai of Paris

Rissho Kosei-kai of Venezia

Rissho Kosei-kai of the UK

29 Ashbourne Road, London W5 3ED, UK
TEL: 44-20-8933-3247 Email: info@rkuk.org URL: <https://www.rkuk.org>
Facebook: <https://www.facebook.com/rkuk.official>
Twitter: https://twitter.com/rkuk_official
Instagram: https://www.instagram.com/rkuk_official

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.ibt-rk.org>